



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 36

Улаанбаатар хот

Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагааны тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.1.5, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4, Хорооны 2013 оны 69 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн тусгай зөвшөөрлийн түр журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын хавсралтад дурдсан нэр бүхий 10 хуулийн этгээдийн хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлснийг 2017 оны 02 дугаар сарын 08-ны өдрөөс сэргээсүгэй.

2. Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсүгэй.

1/ Хавсралтад дурдсан нэр бүхий 10 хуулийн этгээдээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг хөдөө аж ахуйн биржээр арилжаалагдсан худалдах, худалдан авах гэрээний нийт үнийн дүнгийн 0.08 хувиас доошгүй байхаар 2017 оны 02 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн 18 сарын хугацаатай тогтоосугай.

2/ Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангахад холбогдох байгууллагуудтай гэрээ байгуулж ажиллахыг Ажлын алба /Т.Жамбаажамц/, Хяналт шалгалт, зохицуулалтын газар /Б.Ариунаа/-т тус тус даалгасугай.

3. Энэхүү тогтоолтой нийцүүлэн холбогдох дүрэм, журам, биржийн арилжааны системд зохих өөрчлөлтийг оруулж, зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хорооны дансанд сар бүрийн эцэст төвлөрүүлж ажиллахыг “Хөдөө аж ахуйн бирж” ТӨХХК /Х.Баатар/-д үүрэг болгосугай.

4. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргийг чанд биелүүлж ажиллаж цаашид зөрчил давтан гаргасан тохиолдолд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэхийг хавсралтад дурдсан нэр бүхий 10 хуулийн этгээдийн удирдлага, эрх бүхий албан тушаалтанд анхааруулсугай.

5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны
2017 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн
36 дугаар тогтоолын хавсралт



Д/Д	ХААБ-ийн нэрс
1	“Алтан шагай импекс ХААБ” ХХК
2	“Бадархундага оргил ХААБ” ХХК
3	“Баярплант ХААБ” ХХК
4	“МЭТУ ХААБ” ХХК
5	“Танандээж трейд ХААБ” ХХК
6	“Хаантэлмэн ХААБ” ХХК
7	“Ханбүргэд хэнтий ХААБ” ХХК
8	“Цэц-Инвест ХААБ” ХХК
9	“Роял кашимер ХААБ” ХХК
10	“Эрхэм сүрэг ХААБ” ХХК